



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-19

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	6-7
2.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	7-8
3 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай	8-18
4.Батлагдсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулга сонсох	18-19

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 18-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар, Ж.Баясгалан, Б.Бейсен, Б.Заяабал, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Ч.Анар, Х.Баттулга, Б.Батцэцэг, Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Б.Жавхлан, Б.Мөнхсоёл, З.Мэндсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, П.Сайнзориг, Л.Энхнасан, Д.Энхтүвшин;

Тасалсан: Б.Пунсалмаа;

Хоцорсон: Н.Алтанхуяг-02 минут, Д.Батбаяр-01 минут, Ж.Бат-Эрдэнэ-33 минут, Х.Булгантуяа-02 минут, Ж.Галбадрах-02 минут, С.Ганбаатар-24 минут, Д.Ганбат-16 минут, Л.Гантөмөр-31 минут, Т.Доржханд-14 минут, Б.Дэлгэрсайхан-21 минут, Б.Жаргалан-05 минут, Д.Жаргалсайхан-20 минут, Ж.Золжаргал-18 минут, Ц.Мөнхтуяа-08 минут, П.Наранбаяр-01 минут, Ч.Номин-02 минут, Р.Сэддорж-21 минут, А.Ундраа-02 минут, Ч.Ундрэм-20 минут, Г.Уянгахишиг-18 минут, Г.Хосбаяр-17 минут, Да.Цогтбаатар-04 минут, Д.Цогтбаатар-23 минут, Ж.Чинбүрэн-01 минут, Б.Чойжилсүрэн-11 минут.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	49
Татгалзсан:	35
Бүгд:	84

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 26

Бүгд: 90

71.1 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, **анхны хэлэлцүүлэг**, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 36

Бүгд: 90

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 21

Бүгд: 91

76.9 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Баярбаатар, А.Ариунзаяа нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, А.Ариунзаяа, Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллын тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй талаарх Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 27
Бүгд: 106
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Д.Батбаяр, Х.Тэмжин М.Ганхүлэг нарыг дэмжсэнээр тооцож, 78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр олонхын дэмжлэг авсан асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 10 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Батлагдсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:42/

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:42/

3.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:42/

4.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:43/

5.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:43/

6.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:43/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 44 минут үргэлжилж, 126 гишүүнээс 113 гишүүн хүрэлцэн ирж, 89.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. 76 гишүүн бүртгэгдэж ирц 60.3 хувьтай болсон байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдөр Монгол Улсад ХХААХҮЯ байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн өдөр тохиож байна. Тэгээд үүнтэй холбогдуулан ХХААХҮ-ийн салбарын нийт ажилтан албан хаагчид мөн энэ салбарын ард иргэдэд ойн баярын мэндийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэж байна.

Өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Гуравдугаарт, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Хэлэлцэх асуудалд оръё. [Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.](#)

Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан.

Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

49 гишүүн дэмжиж, 58.3 хувиар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

Хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Тэгэхээр санал 64 гишүүнээр дэмжигдэхээр байгаа.

Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 64 гишүүнээр батлагдана.

Санал хураалт.

64 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье ээ.

10.05 цагт

Дараагийн асуудалд оръё. [Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн явуулна.](#)

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Байнгын хорооноос Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

54 гишүүн буюу 60 хувиар санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

Хуулийн төслийг эцэслэн батлуулах хувилбарыг Хууль зүйн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

70 гишүүн дэмжсэн байна. Хуулийн төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье ээ.

10.07 цагт

Дараагийн асуудалд оръё. **Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэнэ.**

ХЗБХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжингээс Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлснийг ХЗБХ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 4 дүгээр сарын 9, 15, 16-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд гаргах саналын талаар танилцуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэж байгаа нь шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших анхны тохиолдол учир энэхүү асуудалд ул суурьтай хандаж Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх гэдгийг анхаарах шаардлагатай талаар, мөн уг асуудлыг хэлэлцэхтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулж гишүүний гаргасан саналтай ойролцоо төрлийн эрх зүйн маргаан байгаа эсэхийг татан үзэж улс төр эрх зүйн үр дагаврыг судлах шаардлагатай талаар, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүний гаргасан саналын зарим үндэслэлтэй санал нийлэхгүй байгаа тохиолдолд засаж сайжруулах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг уг асуудлын талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах бус Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан өргөн мэдүүлэх боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал Үндсэн хуулийн цэцээс хэргийн харьяалал тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлж, шийдвэрлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтнууд Улсын Их Хурлын шийдвэртэй холбогдуулан шүүхэд гомдол гаргах эрхтэй эсэх талаар асуулт асууж, хариулт авч, байр сууриа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын үндэслэлдээ Байнгын хорооны гишүүдийн саналыг нэмж тусган саналаа 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хурлын даргад дахин өргөн мэдүүлснийг ХЗБХ 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах Улсын Их Хурлын гишүүний саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 80 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлнэ гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн нэг дэх хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй талаарх Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах Улсын Их Хурлын гишүүний саналыг хэлэлцсэн ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө.

5 гишүүн нэр ирүүлсэн байна. Ирсэн ирцийн дарааллын дагуу Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэмүүжин гишүүний санаачилсан энэ асуудлыг дэмжиж байгаа.

Тэгэхээр би энэ ноолуурын талаар ярья аа.

Өнөөдөр манай ноолуур яадаг вэ гэж. Манай ноолуур Хятадууд ноолуур аваад Хэбэй муж руу аваачаад Хэбэй мужид тэнд байдаг бүх тэр тосгоноороо бүгдээрээ үйлдвэрлэгч тэр байтугай гэртээ хүртэл юу самнах төхөөрөмж тавьчихсан самнаад тачигнуулаад байж байдаг. Тэгээд тэр авсан ноолуураа буцаагаад заримыг нь Монголын ноолуур гэж Итали руу гаргадаг. Заримыг нь өөрсдийнхөө ноолууртайгаа холиод Хятадын ноолуур гэж гаргадаг, заримыг нь торготой холиод ингээд янз янз бүтээгдэхүүн болгоод явдаг байхгүй юу даа.

Тэгээд энэ самнасан ноолуур гаргах нь маш чухал гэж үзээд Бат-Эрдэнэ гишүүн энэ тогтоолын төслийг санаачлаад 2020 онд батлуулсан. Засгийн газар энийг жил болгон түр зуур хойшлуулаад байсан юм аа. Тэгэхээр ер нь бол 2020 онд дөнгөж 40 тонн ноолуур Итали улс руу самнасан ноолуур гардаг байсан бол яг энэ Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлсний үндсэн дээр мянга орчим тонн болж нэмэгдсэн байгаа. Энэ бол үндэсний үйлдвэрлэгч нарын гавьяа байгаа. Тэгэхээр өнөөдөр Хятад улсад Трамп тарифаас болоод одоо ноолуурынх нь үнэ тэнд таг уначихсан ямар үнээр авахаа мэдэхгүй ийм нөхцөл байдалд байгаа.

Тийм учраас Монголоос ноолуур орж ирж Хятадууд ерөөсөө авахгүй байгаа. Энэний нэг жишээ бол манай Монгол Улсад 3 цагаач иргэн байдаг юм. Ах дүү 3. Тэр 3 хамгийн том ченжүүд нь байхгүй юу. Тэгтэл тэд нар ерөөсөө 1кг ч ноолуур авахгүй байгаа. Энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл Хятадаас мөнгө ирэхгүй байна гэсэн үг. Тэгэхээр өнөөдөр Монголын үндэсний үйлдвэрлэгч нар энэ зүүн аймгийн ноолуурыг нэлээн авсан байгаа. Зүүн аймагт бол ноднин 170 мянган төгрөгөөр ноолуур гарч байсан бол энэ жил 158 мянгаас 165 мянгын хооронд буюу 10 мянган төгрөгийн л бага үнээр манай үндэсний үйлдвэрлэгч нар авсан. Тэгээд одоо ингээд тэд нарын санхүүжилт дуусчихсан байна.

Тийм учраас баруун аймаг руу орж ирэхээр санхүүжилтийн дутагдлаас болоод ноолуурын үнэ унах магадлал байгаа учраас Их Хурлын дарга болон манай парламентынхан нэлээн ярилцаад энэ Монголбанктай хамтарч энэ санхүүжилтийг нь шийдэж өгөх талаар ажиллаж байгаа. Тэгэхээр Засгийн газар энэ дээр тодорхой хүсэлтүүдийг ирүүлээд энэний үр дүнд ноолуурын үйлдвэрүүдийг дахин санхүүжүүлсний үр дүнд баруун аймгаас ноднин 130-аас 135 мянган төгрөгийн хооронд ноолуур авч байсан бол энэ жил 120 мянган төгрөгөөс буулгахгүйгээр ноолуур авах ийм төлөв байдал харагдаж байна аа. Тэгэх дээр Хятадууд өнөөдөр бидний ноолуурыг ихэнхийг нь бараг 10 мянган тонн ноолуурыг нь бараг 7, 8 мянган тонныг нь аваад явчихдаг. Гэтэл өнөөдөр энэ жил бид нар Хятадын ченжүүдэд мөнгө байхгүй учраас бид нар дотооддоо энийг худалдаж авахаас өөр аргагүй. Үүний үр дүнд бид нар бүгдэнг нь самнаад л гарах ийм боломжийг бий болгож байгаа юм аа. Энэ самнах хүчин чадлаас болж ерөөсөө энэ үнэ унахгүй байгаа.

Ер нь Хятадын ченжүүд орж ирэхгүй байгаагаас болж энэ жоохон бага зэрэг үнэ унаж байгаа шүү. Тэгэхээр энэ жил Монголчууд бүгдээрээ малчид бүгдээрээ тэвчье. Бүгдээрээ Монголдоо ноолуураа самнадаг болгоод ингээд гарах юм бол хойтон жилээс эхлээд Италиас тэр Францаас дээрээс нь Хятадаас самнадаг үйлдвэрүүд орж ирээд эндээ нэмүү өртөг бий болгоод гаргаад явах юм бол нөгөө Энхбаяр сайдын хэлсэнчлэн 700 тэрбум төгрөгийг дотооддоо авч үлдэх ийм боломж гарч ирж байна аа.

Тийм учраас манай малчид минь нэг 10 мянган төгрөг дээр тэвчээд тэгээд энэ энэ жил 10 мянган төгрөгөөр л унаа биз. Тэгээд зарим нэгэн зардлаа хэмнээд одоо энэ Монголдоо үйлдвэрлэлийг бий болгож ноолуураа дэлхий даяар 50 хувийг нь үйлдвэрлэдэг мөртөө үнээ тогтоож чаддаггүй энэ байдлаа буцааж бид нар өөрсдөө үнээ тогтоодог энэ эрүүл орчныг авчиръя гэдэг ийм л уриалгыг гаргаж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн ноолуурын талаар ярилаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууж үг хэлье.

Б.Энхбаяр: Гишүүддээ баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж болсноос хойш 33 жилийн түүхэнд Монгол Улсын Их Хурлаас анх удаа Үндсэн хуулийн цэцэд хандан Үндсэн хууль зөрчсөн, тодорхой хууль зөрчсөн эсэх асуудлаар хүсэлт гаргах гэж байгаа юм. Тэр утгаараа энэ бол анхны жишиг тохиолдол болж байгаа гэдэг маань цаашаа тийм периздентийг эхлүүлж байна. Энэ бол би их зөв жишиг болох байх гэж бодож байна.

Тийм учраас Улсын Их Хурлаас хүсэлт гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн цэц маргаан үүсэх үү үгүй юу гэдэг асуудлыг хэлэлцдэггүй. Шууд үүсгэдэг. Шууд

үүсгээд Цэц бүрэн бүрэлдэхүүнээрээ шууд хуралдаж энэ асуудлыг шийдвэрлэдэг онцгой тийм горимтой. Тэр утгаараа энэ тохиолдлыг би дэмжиж Тэмүүжин гишүүн ч гэсэн үндэслэлээ нэлээн нухацтай сайн боловсруулж орж ирсэн учраас дэмжиж байгаа юм аа. Энэ бол ингээд дараа дараагаар үргэлжлэх нь ээ. Цаашдаа Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд олон асуудлаар би хүсэлт гаргах байх гэж бодож байна. Тухайлбал миний хувьд энэ Пүрэвдорж, манай Сандагаа байна. Өөр чинь хэн байлаа Цогтбаатар дарга эд нар гээд бид нар өнгөрсөн парламентын үед энэ шүүхээс буцаадаг асуудлыг болиулсан юм уг нь. Нотолж чадахгүй бол цагаатга гэдэг ийм зарчмыг Эрүүгийн процессын хуульд суулгасан.

Харамсалтай нь шүүх үзэмжээрээ зарим хүмүүсийн хэргийг шүүхээс буцаагаад байгаа. Өөрөөр хэлбэл бидний баталсан хуулийг тодорхой кэйс тохиолдлууд дээр хүнээс нь ялгамжтай хандаж авч үзэж байгаа тохиолдлууд гарч байна аа. Тухайлбал одоо миний ойлгож байгаагаар энэ найдлаа гишүүн Алтанхуяг гишүүдийн хэргийг шүүх шүүхээсээ буцаачихсан гэж би ойлгоод байгаа. Энэ бол шүүхээс дээд шатын шүүхээс тооцсоны шүүхэд чиглэл даалгавар өгч байгаа асуудал.

Өөрөөр хэлбэл нотлогдохгүй бол хүнийг цагаатгах ёстой, нотлогдож байгаа бол шууд ялаа өгөх ёстой. Тэрнээс биш чи ийм ял өгөөд ир, чи ингээд өг гэж ийм чиглэл даалгавар өгдөг байгууллага бол шүүх биш. Мөн прокурор мөрдөн шалгах байгууллагын дутуу хийсэн ажлыг шүүх гүйцээдэг байгууллага биш. Тийм учраас бид ХЗБХ-ны гишүүд хамтдаа энэ асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандаж энэ асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн хэмжээнд эцэслэн мухарлах санал хүсэлт гаргая гэсэн ийм санал бодолтой байгаа. Өчигдөр Алтангэрэл сайд нэг мэдэгдэл хийчихсэн байна лээ. Энэ Даваагийн Цогтбаатар гишүүний асуудлаар.

Улсын дээд шүүхийн эцсийн шийдвэр гараад гэм буруутай гээд үзчихсэн. Энэ бол хуулийн мухардалд орчихсон гээд хэлчихсэн байна лээ. Хуульд мухардал гэж байдаггүй. Хууль мухардсан бол Үндсэн хуулийн цэц өөрөө энэ мухардлыг арилгаж байх ийм чиг үүрэгтэй.

Хэрвээ Улсын Их Хурлаас мухардчихаад байгаа юм бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж энэ асуудлаа шийдвэрлэгдэх ёстой. Бид Улсын Дээд шүүхийн шийдвэр эцсийн байна гэсэн Үндсэн хуультай мөртөө Улсын Их Хурал нь ард иргэдээсээ хууль биелүүллээ гэж шаардаад байх улс төр эрх зүйн ёс суртахууны эрх байхгүй болж байгаа юм.

Тийм учраас би энэ Даваагийн Цогтбаатар гишүүнийг би хүнийх нь хувьд ерөөсөө ярьж байгаа асуудал биш. Та ойлгож байгаа байх гэж бодож байна. Би Хөгжлийн банкны хэргийг үзэж байхад ч гэсэн энэ Даваагийн Цогтбаатар гишүүнийг би гэм буруутай эд нар гэж би олж харж байгаагүй. Жишээлбэл. Тэгэхдээ шүүхийн шийдвэр гарчхаад байна. Улсын Их Хурал энэ дээрээ жишээлбэл.

Д.Амарбаясгалан: Энхбаяр гишүүн үг хэллээ.

Тэмүүжин гишүүн тайлбар хийх үү? Хууль санаачлагч Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Үнэхээр Энхбаяр гишүүний хэлж байгаачлан 33 жилийн түүхэнд анх удаагаа Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж байгаа. Хүсэлт

гаргах болсон шалтгаан бол нэлээн ньуанстай. Монгол Улсын Үндсэн хуулиар Улсын Их Хурлын шийдвэр зөвхөн Үндсэн хуулийн цэцэд хянагддаг Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар. Гэтэл өнөөдөр практикт дээр юу болсон бэ гэхээр Монгол Улсын Их Хурлыг ердийн шүүх дуудаж байгаа. Улсын Их Хурлын тэмдэглэл, хуралдаанаар шийдсэн асуудал, шийдэх болсон үндэслэл гэх мэтчилэн олон зүйлийг шүүх нотлох баримтын хэмжээнд гаргаж өг гэж шаардаж байгаа. Улсын Их Хурал итгэмжилсэн төлөөлөгчөө энэ хуралдаанд томил гэж хэлж байгаа. Агуулга нь юу байсан бэ гэхээр Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын даргыг томилсон чөлөөлсөн асуудлаар нэг иргэн гомдол гаргасан. Энэ практик хууль ёсоор ингээд цаашаа үргэлжлэх юм бол Улсын Их Хурал, Ерөнхий сайдыг огцруулах Улсын Их Хурлаас ямар нэгэн албан тушаалтныг томилох асуудлаар томилогдоогүй хүн Улсын Их Хурлыг шүүхэд өгөх хэмжээний тийм гажуудал үүсэх гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ гажуудлыг бид засах ёстой. Монгол Улс бол парламентын засаглалтай гэж ярьдаг. Үндсэн хууль дээр төрийн эрх барих дээд байгууллага бол Улсын Их Хурал гэж хэлдэг. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдана. Улсын Их Хурал бол Монгол Улсын гадаад дотоод бүхий л асуудлыг авч хэлэлцэх эрхтэй гэж Үндсэн хуулийн заалт байгаа. Энэ Үндсэн хуулийн хил хязгаарыг ердийн шүүх давж алхаж ерөөсөө болохгүй. Тэгээд энэ гажгийг таслан зогсоох нэг арга зам бол одоо энэ цэцтэй холбоотой хүсэлт илэрхийлэх. Яагаад ийм гажиг үүссэн бэ гэхээр Улсын Их Хурал сүүлд Шүүхийн тухай хууль дээр Дээд шүүх харьяалал нь тодорхойгүй маргааныг шүүхийн харьяаллыг тогтоож өгч болно гэдэг байдлаар бичсэн.

Гэтэл 1997 онд Цэцийн тухай хууль дээр яг ийм заалт орчихсон юм байна лээ. Үндсэн хууль дээр бол Цэцэд ийм эрх мэдэл олгогдоогүй байгаа. Яг энэ асуудлаар иргэн гомдол гаргасаар байгаад Үндсэн хуулийн цэцээс шүүхийн харьяалал тогтоогоод Захиргааны шүүхэд Улсын Их Хурлыг аваачаад өгчихсөн юм байна лээ. Тэгэхээр Улсын Их Хурлаас нийтийн захиргааны байгууллага шиг болж хувирч байгаа. Энэ бол Үндсэн хуулийн дэг журам, Үндсэн хуулийн суурь байгуулал өөрөө ганхахад хүрэх хэмжээний эрсдэлтэй үр дагавар учраас энэ асуудлыг шийдэхийн тулд энэ арга замаар бид явж байгаа юм аа. Та бүхэн өнөөдрийн энэ асуудлыг хариуцлагатайгаар дэмжээд өгөөрэй гэж хүсэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууж үг хэлье.

Б.Баярбаатар: Тэмүүжин гишүүний энэ өргөн барьсан асуудлыг бол дэмжиж байгаа юм. Гишүүдийгээ дэмжиж өгөөч гэж хүсье. Хуулийн нэлээн тийм ньуанстай асуудал. Энэ дээр бий болчихоод байгаа юм.

Улсын Их Хурлын гарсан шийдвэрийг гаргасан шийдвэр эрх зүйн актыг Үндсэн хууль зөрчиж байна уу эсэх талаар нь цэц хянан шийдвэрлэдэг болохоос биш шүүхийн харьяалал тогтоох нь өөрөө эрх зүйн маш том гажуудал үүсгэхэж байгаа юм. Тэгээд Цэц нь өөрөө хуульд нь тусгаад өгчихсөн болохоор тэрийг аргагүйн эрхэнд бариад ингээд шүүхийн харьяалал тогтоогоод захиргааны хэргийн шүүх рүү ингээд асуудлыг шилжүүлээд явуулчихдаг. Тэгээд өнөөдөр ингээд үүсэж байгаа нөхцөл байдлыг нь сая Тэмүүжин гишүүн тайлбарлалаа. Энэ дээр гол нь ингээд Цэц Энхбаяр гишүүний хэлснээр ингээд хэрэг үүсгээд Үндсэн хууль зөрчлөө гээд гарч ирсэн тохиолдолд Их Хурал буцаж авч хэлэлцээд тэр хуулийн заалт нь хүчингүй болох юм уу нэг тийм өөрчлөлт орох байх.

Гэтэл өнгөрсөн хугацаанд яг энийгээ дагаад өнгөрсөн хугацаанд гарсан энэ шийдвэр ялангуяа тэр цэцийн гаргасан шийдвэр, цэцийн шийдвэрийг үндэслээд захиргааны хэргийн шүүх дээр үүссэн маргаан эд нар бүгд дагаад хүчингүй болох ийм боломж байгаа юу гэдгийг би Тэмүүжин гишүүнээс асууж байна. Нэг талаараа энийг протоколд тусгах нь зөв.

Гэтэл бид нар энэ хуулиа өөрчилчхөөд тэгээд буцаагаад эд нар нөгөө өнгөрсөн юмыг бид нар энэ хууль буцаж үйлчлэхгүй ч гэдэг юм уу ийм тайлбар хийгээд тэр нь тэрүүгээрээ явчих вий гэдэг ийм асуудал байгаа. Ер нь цаашдаа энэ Их Хурал яг энэ хуулийн гажуудал. Бид нар өөрсдөө ч гэсэн давхар хараад өнөөдрийн энэ жишгээр энэ Үндсэн хуулийн цэцэд хандаж засуулах энэ хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийх ийм зүйлүүд нэлээдгүй гарах байх гэж харж байгаа. Их зөв жишиг тогтож байгаа гэж харж байгаа юм. Тэгээд тэр аудитын дарга байсан нөхөр л юм байна лээ л дээ. Хүрэлбаатар гээд нэг зангууны үлгэр шиг л юм. Тэгээд л Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүх, Үндсэн хуулийн цэцэд хэд хэдэн удаа хандчихсан юм байна. Тэгээд нэг ийм залчихсан бурхан шиг тэгээд нэг ажил албан тушаал дээр очоод хариуцлагатай ажиллаж чадахгүй байж байгаад ажлаас чөлөөлөгдөнө. Эс үгүй бол өөрөө хүсэлтээрээ сонгуульд нэр дэвшинэ гээд ажлаасаа чөлөөлөгдчихнө.

Тэгээд дэвшиж чадахгүй болохоороо буцаад ингээд Их Хурал руу дайраад, Үндсэн хуулийн байгууллага руу дайраад ингээд ийм нөхцөл байдал үүсгээд байдаг нь өөрөө энэ чинь маш өндөр ёс суртахуунгүй асуудал байхгүй юу. Тэгээд энийг нь бий болгох боломжийг нь олгоод өгчихсөн энэ хууль эрх зүйн актыг бид нар засах нь зөв гэж харж байгаа. Тэгэхээр гишүүд энэ дээр дэмжиж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Тэмүүжин гишүүн асуултад хариулъя.

Х.Тэмүүжин: Баярбаатар гишүүний асуулт бас ХЗБХ-н дээр гарсан. Сайнзориг гишүүн бас яг энэ агуулгатай асуултыг асуусан. Улсын Их Хурал өөрөө хуулиа өөрчлөөд асуудлыг шийдээд явчхаж болно шүү дээ. Бидэнд тийм эрх байгаа. Санаачлаад явах уу гэдэг ийм хувилбарын тухай ярьсан. Хууль өөрчлөгдсөн ч гэсэн нөгөө Цэцийн гаргасан магадлал өөрөө өөрчлөгдөхгүй. Цэцийн гаргасан магадлал ямар тохиолдолд өөрчлөгдөх вэ гэхээр Цэц магадлалаа эргэн харахын тулд нөгөө энэ хуультай холбоотой асуудлаа шийдэх ёстой. Энэ асуудлыг шийдэхийн тулд гарц нь юу байна вэ гэхээр Улсын Их Хурлаас ямар нэгэн хүсэлт ирэх ёстой. Энэ 3 нөхцөл давхцаж байж сая Цэцийн гаргасан магадлал тэр магадлалын дагуу шүүх дээр явж байгаа процесс өөрөө зогсох ёстой юм. Тэгээд яах аргагүй сая Баярбаатар гишүүний хэлдэг бол жоохон увайгүй байгаа юм. Тэр хүний хувьд бол.

Монгол Улсын ерөнхий аудитор байсан. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа сонирхлын зөрчлийн хуулиар Ерөнхий аудитор хүн төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч байх хориотой байсан. Гэтэл мань хүн өөрөө ЖДҮ-лэлийг дэмжих сангаас зээл авчихсан. Санхүүгийн хариуцлагыг хамгийн дээр нь зогсоод хянаж байх ёстой хүн нь өөрөө очоод зээл авчихсан ийм асуудал хөндөгдөөд тэгээд Улсын Их Хурлаас дээр нэлээн хэлэлцүүлэг болоод тэгээд дээр нь өөрөө бас Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэр дэвших сонирхолтой байна гээд өөрөө хүсэлтээ

өгсөн. Бас хариуцлага хүлээх гэдэг 2 үйл явц нь давхцаад чөлөөлөгдсөн. Гэхдээ одоо өөрөө бүх шатны шүүхээр гүйж буцаж аудитор намайг Улсын Их Хуралд томилох ёстой гэдэг ийм шаардлага тавиад яваад байгаа. Энэ асуудал нь зүгээр зарим талаараа увайгүй гэж хэлж болно.

Цэц дээр очсон юм байна лээ. Үндсэн хуулийн цэц маш үндэслэлтэй хариу өгсөн юм байна лээ. Энэ бол шүүхийн асуудал биш байна гэж. Тэгээд дараа нь дахиад шүүх рүү ийш тийшээ шийдэгдэж яваад 2 дахь удаа Цэц дээр очихдоо одоо Цэцэд байхгүй. Бүрэн эрхээ чөлөөлөгдөөд гарчихсан байгаа 2 хүн алх цохиод гараад явчихсан юм байна лээ. Тэгээд үл ойлгогдох ийм байдал үүссэн. Энэ байдлыг засах арга зам байна.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж үг хэлье.

А.Ариунзаяа: Тэмүүжин гишүүн энэ хариуцлага тооцуулж чөлөөлөгдсөн гэдэг чинь миний мэдэх мэдээлэл биш байна. Миний мэдэх мэдээллээр бол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр нэр дэвших хүсэлтэй байсан учраас хуулийн дагуу 12 сарын 31-ээс өмнө ажлаа өгөх ёстой гэдэг энэ хуулийн дагуу ажлаа өгөх хүсэлтээ өгч чөлөөлөгдсөн. Харамсалтай нь улс төрийн нам дээр ирээд Их Хурлаар бага хурлаар нэр дэвшигчээр сонгогдоогүй учраас эргүүлээд намайг тавиагч гэдэг ийм асуудлаар Улсын Их Хурлыг шүүхэд өгч байгаа ийм маргаан үүссэн гэж ойлгосон.

Хэрэвзээ хариуцлага тооцуулсан байсан бол таны хэлж байгаачлан тийм тийм байсан бол шүүхэд эргэж хандахгүй байх болов уу. Энэ бол арай өөр харилцаа. Тэгээд үүнтэй холбогдуулан яах вэ шүүхэд өөрөө өгч байгаа нь эргээд намайг ажилд тавиагч, яагаад намайг чөлөөлчхөв гэж тавьж байгаа нь өөрөө хууль зөрчиж байгаа харагдаж байгаа үнэн. Ер нь бол Улсын Их Хурлаар өөрөө хүсэлтээ өгч чөлөөлөгдчихөөд эргээд намайг тавьсангүй гэж улсын Их Хурлаа шүүхэд өгөх нь бол буруу.

Гэхдээ үүнтэй холбогдуулан би бас Пүрэвдорж гишүүнтэй адил микрофоныг ашиглаж юуг хэлэх гээд байна вэ гэхээр ер нь энэ Сонгуулийн тухай хуулийн бидний хүлээж авсан энэ Цэцийн шийдвэртэй холбоотой ажлын тайлангаа хүн болгон аливаа этгээд нээлттэй тавьж болохоор болчихлоо шүү дээ. Тэгэхээр ер нь 12 сарын 31-ээр албан тушаалтан ажлаа заавал өгөх ёстой юу үгүй юу. Энэ өөрөө эргээд Улсын Их Хурлын гишүүн ажлаа өгөхгүйгээр Улсын Их Хуралд нэр дэвшээд байгаа нь өөрөө давуу байдал үүсгэж байгаа биз дээ. Энэ ерөнхий концепцоор нь ингэж авч үзэх юм бол. Тэгэхээр ер нь албан тушаалтнууд нэр дэвших хүсэл тээсэн ч бай, үгүй ч бай заавал эрхээ аваагүй байхад наана нь ажлаа өгөх нь зохистой юм уу, хүний эрхэд нь халдаад байгаа юм биш биз дээ. Энийг бас Сонгуулийн тухай хуулиа эргэн харж үзэх ёстой юм биш үү гэдэг ийм саналыг хэлэх гээд байна.

Тэгээд Тэмүүжин гишүүнээс саяын яг хариуцлага тооцуулж чөлөөлөгдсөн юм уу эс үгүй бол нэр дэвшигч болно гэсэн өөрийн хүсэлт тээж ажлаас чөлөөлөгдөх ийм хүсэлтээ өгч байсан юм уу. Цаашлаад энэ ажлаа заавал 12 сарын 31-ээс өмнө өгдөг байх харилцааг зохицуулах шаардлагатай юу, үгүй юу гэдгийг хуульчийн зүгээс тайлбарлаж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн хариулт өгье.

Х.Тэмүүжин: Та бүхэн бүгдээрээ тэр үйл явдлуудыг санаж байгаа байх. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод гарсан. Тухайн үеийн Улсын Их Хурлын дарга М.Энхболд гэдэг хүний албан өрөөнд яг энэ асуудлаараа ярилцаж байгаа бичлэг телевизээр ил тод гарсан. Тухайн үеийн Их Хурлын дарга шаардлага тавьж байгаа, ЖДҮ-лэлийн зээлийн сангаас зээл хүртчихсэн энэ асуудал чинь хөндөгдөөд байгаа учраас ажлаа өг гэж би хэлж байна гэдэг үг тэр бичлэг дотор ил тод гарсан. Тэгээд бидний нэг хариуцлагагүй л асуудал. Хариуцлага тооцох ёстой газар хариуцлага тооцохгүй. Яг шийдвэр гарах болохоороо манай нам юм, манай нутаг юм, за яах вэ гэж толгойг нь илээд өөрийнх нь хүсэлтээр гээд хүсэлтийг нь аваад гаргадаг. Энэ улс төрийн буруу практик хүнийг ингэж өөгшүүлж байгаа байхгүй юу. Ярьсан эхний үндэслэл бол хариуцлага тооцох. Тэгээд албан ёсны шийдвэр гарах нь бол өөрийнхөө хүсэлтээр. Ийм юм болж хувирсан. Тэгээд бид бол энэ завхралыг засах ёстой. Улсын Их Хурлын дарга хоёронтой хэлэх шиг болно лээ. Улсын Их Хурал дээр импиж тооцдог, хариуцлага тооцдог, хууль зөрчсөн алдаа гаргасан энэ Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг албан тушаалтнуудыг толгойг нь илэлгүйгээр илэрсэн фактаар нь хуулийг нь бариад шийдвэр гаргадаг болохгүй бол хэсэг хугацааны дараа мартчихсан юм чинь би ингээд буцаад орчих байх гэдэг нэг ийм хэл аманд дарагдаад иргэд загасны ой санамж шиг ийм богинохон учраас би буцаад ажилдаа оръё оо гэдэг юм цаашаа бол гарч магадгүй ээ.

Тийм учраас одоо бид нар зарим зүйл дээр хатуу байх ёстой. Алдаа гаргасан бол алдааг нь хэлээд хариуцлага тооцдог байх ёстой. Тэрний юм, энэний юм гэж толгойг нь илдэг байдал одоо Монголд энэ хариуцлагагүй ардчилал бий болгож байна л гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Тэмүүжин гишүүн саяын субъектээс гадна, нийтлэгээр 12 сарын 31-нд ажлаа өгөөд нэр дэвшиж чадахгүй байх ийм тохиолдлууд нэлээдгүй байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн ажлаа өгөхгүйгээр Улсын Их Хурлын дараагийн сонгуульд орж байгаа нь бол өөртөө давуу байдал үүсгээд байна шүү дээ тийм үү?

Тэрэнтэй нэгэн адилаар өчигдөр бид нар шийдсэн уулзалтыг аливаа этгээд хийж болно гэдэг өнөөдөр хүртэл энэ шийдвэрийг гаргалаа шүү дээ. Тэгэхээр үүнтэй нэгэн адилаар ер нь цаашид 12 сарын 31-ээр ажлаа өгөх нь зөв юм уу? Нэн ялангуяа яах вэ бид нар энэ том албан тушаалтнуудыг яриад байна. Энэнээс гадна сум орон нутаг, хөдөө нутагт ажлаа өгчхөөд юугаа бодож суух вэ? Ийм учраас төрийн албан хаагчид бол яг мэдлэг чадвартай хүмүүс нэр дэвшигчээр ажиллахаасаа илүүтэй ажлаа бодож ажилтайгаа үлдэхийг бодож байна аа.

Тэгэхээр энэ бол яг энэ иргэдийн төлөөлөл болоод ер нь энэ нэр дэвшигчдийн чанарыг бол сулруулж байгаа нэг явдал байна аа. Тэгэхээр цаашдаа бол.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууж үг хэлье.

Л.Мөнхбаатар: Тэмүүжин гишүүний гаргасан энэ хүсэлт өөрөө Үндсэн хуулийн эрх зүйн томоохон асуудлыг хөндчихсэн асуудал болчхож байгаа юм. Энэ өөрөө төрийн эрх мэдэл хуваарилах зарчимтай холбоотой суурь асуудал л даа. Улсын Их Хурлын шийдвэрийг шүүх хянах уу үгүй юу гэдэг асуудалтай холбогдож

гарч байгаа ийм хүсэлт. Ер нь Улсын Их Хурал, Дээд шүүх бол Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй байдаг. Их Хурал бол яах вэ анх удаагаа гаргах гэж байна. Дээд шүүх бол нэлээн хэдэн удаа гаргасан байдаг. Хүсэлт гаргаж тодорхой тодорхойгүй зүйлүүдийг тайлбарлуулах ийм хүсэлтүүдээ гаргаж тодорхой шийдвэр гаргуулсан байдаг юм. Энд бол яах вэ ийм зүйлүүд харагдаад байгаа юм.

Их Хурлын шийдвэрийг бол ер нь Үндсэн хуульд зааснаар Цэц л хянах эрхтэй. Тэрнээс биш шүүх хянадаггүй. Их Хурал өөрөө хууль гаргаж байгаа тогтоол гаргаж байгаа. Тийм учраас тодорхой албан тушаалтныг томилсон чөлөөлсөн асуудлууд тогтоол хэлбэрээр гарч байгаа учраас үүнийг шүүх хянах ийм боломжгүй гэдэг нь бол тодорхой харагдаж байгаа юм. Гэхдээ энд ийм нэг зөрчилтэй 2 зүйл гарчхад байгаа юм. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд бол ҮХЦ-ийн харьяалах маргааныг тодорхой заагаад өгчихсөн. Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль дээрээ болохоороо тодорхой нэг зүйлийг нэмээд биччихсэн. Энэ нь болохоороо аль ч шүүх хэлэлцэхгүй байгаа маргааныг харьяалал дээр тогтоох эрхийг бол Цэцэд ингээд олгочихсон. Энэ заалтыг аваад сая бол нь энэ Цэцийн магадлал гаргаад Захиргааны хэргийн шүүхэд энэ хэргийг шилжүүлчихсэн байгаад байгаа юм.

Энэ бүрэн эрх өөрөө Үндсэн хуульд олгогдоогүй бүрэн эрх байж байгаа. Тийм учраас энэ асуудлыг бол шийдэх шаардлагатай. Энэ тал дээр Цэц өөрөө энэ магадлалаа бас эргэн харах шаардлага байна. Энэ магадлал гарсны дараа энэ Цэцийн хуульд маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд бол энэ өөрчлөлтийг оруулах байх. Ингэхдээ харин шүүхийн хуульд бол тодорхой өөрчлөлтүүдийг илүү боловсронгуй хамтад нь хийгээд явах нь зүйтэй байх гэж бодож байгаа юм. Шүүхийн хуульд бол ер нь өөрөө шүүхийн харьяалал маргааныг бол өөрөө шүүх өөрөө тогтоохоор заачихсан ийм заалт нь байж байгаа.

Тэгэхээр шүүх өөрөө шүүхийн маргаан харьяаллаа өөрөө тогтоодог байтал мөн адил цэц маргааныг харьяаллыг тогтоохоор ингээд давхардуулж заасан. Энэ бол өөрөө хоёрдмол утгатай зөрчилтэй ийм заалт болчихоод байгаа юм. Тийм учраас энэ 2 хуулийн заалтыг хоёуланг нь засаад нэг талд нь уг заалтыг бол Цэцийн процессын хуулиас авах хэрэгтэй. Нөгөө талдаа шүүхийн энэ процессын хуулийг нь ч гэсэн илүү тодорхой болгох ийм шаардлага байгаа гэдгийг хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь энэ бол Үндсэн хуулийн цэцэд энэ Үндсэн хуулийн цэцээс энэ тодорхой энэ хэрэг маргаантай холбоотой энэ асуудал дээр нэмэлтээр ийм үүрэг хүлээгч маргааныг харьяалал тогтоодог үүрэг хүлээх нь их зохимжгүй гэдгийг бол энд зориуд хэлье гэж бодож байгаа юм.

Тийм учраас энэ асуудлаа бол цаашдаа ингээд цэгцлээд явах нь зүйтэй. Одоо ҮХЦ-ийн тухай хууль Цэцэд маргаан шийдвэрлэх тухай хуулийн Улсын Их Хурлын даргаас байгуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Удахгүй 5 сарын 5 6-нд Венецийн комиссоос холбогдох зөвлөх багууд ирж ажиллана. Венецийн Комисст энэ 6 сард энэ манай хуультай холбогдуулан зөвлөмж өгнө. Энэ чиглэлээр ажлын хэсгийнхэнтэй уулзана. Үүний дараа бид бас энэ зөвлөмжийг авч үзнэ. Түүнийхээ дараа холбогдох хуулийг энэ намрын чуулганд оруулахаар байгаа. Ингээд Цэцийн хууль, Цэцийн хэрэг маргааныг шийдвэрлэх хуулиа илүү боловсронгуй болгох ийм шаардлагууд байгаа. Энийгээ цогцоор нь бид нар авч үзнэ гэж бодож байгаа. Ийм учраас энэ Тэмүүжин гишүүний оруулсан энэ саналыг дэмжиж байгаа. Энэ бол

харин хоёрдмол утгагүй тодорхойгүй байдлыг арилгах, шүүх эрх мэдлийг нь оновчтой болгоход их чухал санал болж байгаа гэж үзэж байгаа.

Цаашдаа ч гэсэн олон зүйлүүдийг ингээд энэ анхны хүсэлтийнх нь дараа олон зүйлүүдийг нь тодорхой болгоод Их Хуралд хүсэлтээ тавиад явдаг ийм практик тогтоох нь зүйтэй гэж үзэж байгаагаа хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

Пүрэвжавын Ганзориг гишүүн санал хураалт суудалдаа сууя.

Даваасүрэн гишүүн горимын санал.

Ц.Даваасүрэн: Энэ Улсын Их Хурлын гишүүн Цэцэд ханддаг асуудал маш чухал асуудал байхгүй юу. Тэгэхдээ энэ дээр нэг ийм буруу юм яваад байдаг юм. Энэ чинь анх удаагаа биш юм. 2022 онд би хандсан юм. Тэгэхээр энэ дээр нэг дэг дээр нэг юм байдаг юм. Энийг л анхаараач гэж би хэлэх гээд байгаа юм. ХЗБХ-оор оруулж хэлэлцдэг байхгүй юу. Тэгээд гишүүн хүн гомдол гаргаад өгч байхад ХЗБХ-оор хэлэлцэхгүй байсаар байгаад тэгээд дараад өнгөрчихсөн байхгүй юу.

Тэгэхээр цаашдаа тэгмээргүй байгаа юм. Ийм хуулийн зөрчилтэй асуудлууд гараад ирвэл Их Хурлын гишүүн шууд иргэний хувьд хандахгүйгээр шууд ингээд хандаад явчих энийгээ нээлттэй, чөлөөтэй болгох хэрэгтэй. Тэгэхгүй ХЗБХ-оор нь хэлэлцэж өгөхгүй байсаар байгаад тэгээд л нэг бүтэн чуулганы хугацаа өнгөрөөчихсөн байхгүй юу. Тэр нь бол нөгөө Үндсэн хуультай холбогдолтой маргааны Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдолтой маргааны асуудал хөндсөн юм. Тэгэхээр хэлэлцэж өгөөгүй юм. Тэгээд уг нь энийг 1 тэгэхгүй хүнд суртал гаргахгүйгээр Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө яаралтай энэ хуулийн зөрчилтэй асуудал байвал шийдээд явчихдаг байх юм бол энэ их чухал.

Тийм учраас цаашдаа ялангуяа энэ гишүүд ингэж хандах юм бол тэр ХЗБХ-н дээр хэлэлцдэг асуудлыг нь аль болох ямар нэг хүнд сурталгүйгээр зайлшгүй хэлэлцдэг байхаар зохицуулж өгөхгүй бол болохгүй.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүний ярьж байгаа асуудал өөрөө Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.1 дээр тодорхой заачхаж. Монгол Улсын үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг ХЗБХ ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал дүгнэлтээ оруулна гээд заачихсан байгаа.

Энэ дээр анхаарч ажиллана аа. Ер нь тэгээд энэ Үндсэн хуулийн цэцээс гарч байгаа дүгнэлттэй холбоотой асуудал Улсын Их Хурлаар бас олон удаа орж хэлэлцэгддэг. Тэгээд ХЗБХ-нд чиглэл өгсөн, Тамгын газар чиглэл өгсөн байгаа нь ирсэн дүгнэлттэй холбоотой мэргэжлийн тайлбарыг мэргэжлийн түвшинд гаргаж Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж хэрхэн санал өгч оролцох талаар бас мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаж байх шаардлагатай гэж үзсэн байгаа. Тэгэхгүй бол гишүүдээс тавьж байгаа хүсэлт нь тухайн Цэцийн дүгнэлттэй

холбоотойгоор яг санал өгөхтэй холбоотой онолын болон мэргэжлийн тийм тайлбарууд хэрэгтэй байна гэдэг ийм санал хүсэлтүүд ирж байгаа.

Тэгэхээр энэ дээр Тамгын газар их онцгой анхаарч ажиллах нь зүйтэй юм гэж ингэж үзэж байна аа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллын тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй талаарх Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

79 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннямын Гантөмөр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Далайн Батбаяр, Мөнгөнцогийн Ганхүлэг нарын гишүүдийг дэмжсэнээр протокол тэмдэглэе ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр олонхын дэмжлэг авсан асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргах хүсэлтийг албан бичгээр хүргүүлнэ ээ.

10.43 цагт

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна аа.

1.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал ингээд дуусаж байна. Тэгээд Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл өнөөдөр СЗХ-н дээр очиж ажиллахаар байгаа. ББСБ болон санхүүгийн үйлчилгээтэй холбоотой нарийвчилсан мэдээллүүдийг Улсын Их Хурлаас авч ажиллахаар байгаа гэдэг зарыг хүргэе ээ. Баярлалаа гишүүдэд.

10.44 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА